



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/256

Улаанбаатар хот


**“Сүхбаатар дүүргийн 42 дугаар
цэцэрлэг”-ийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 2,356,800.0 /Хоёр сая гурван зуун тавин зургаан мянга найман зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэг /Д.Цэрэндолгор/-т зөвшөөрсүгэй.


2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэг /Д.Цэрэндолгор/-т /-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 10 өдрийн 7/1256 дугаар тушаалын хавсралт



Хандивын хөрөнгө бүртгэх тухай

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Чанар байдал	Үйлдвэрлэсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Хандивлагч байгууллага
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Ханын шкаф		шинэ	2018	ш	5	350,000	1,750,000	Эцэг эхийн
2	Зурагт	TCL-40D3000	шинэ	2018	ш	1	606,800	606,800	эцэг эхийн
ДҮН								2,356,800	